

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/064/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Нурлан
Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. хэсэг .	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	УЛААНХУС СУМЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.БЕРДЕНБЕК ТАНАА
2025.02.25 № 223 танай _____ -ны № _____ -т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Улаанхус сумын 1 дүгээр сургууль нь 2024 онд 4,172.3 сая төгрөгийн батлалдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 3,773.9 сая төгрөг зарцуулж, 90.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь</p>	

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>310,126,461.29</u>	<u>518,309,240.65</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	214,443,487.00	379,174,131.86
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	214,443,487.00	379,174,131.86
3121	Төгрөг	214,443,487.00	379,174,131.86
31211	Төрийн сангийн харилцах	214,443,487.00	379,174,131.86
33	АВЛАГА	0.00	4,350,900.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	4,350,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	95,682,974.29	134,784,208.79
351	Түүхий эд материал	0.00	600,000.00
35130	Эм боох материал	0.00	600,000.00
354	Хангамжийн материал	95,682,974.29	134,184,208.79
35410	Бичиг хэргийн материал	0.00	7,150,000.00
35420	Аж ахуйн материал	54,917,035.29	96,669,345.79
35440	Түлш, шатах тослох материал	0.00	71,400.00
35460	Хүнсний материал	20,931,916.00	10,459,440.00
35470	Бусад хангамжийн материал	19,834,023.00	19,834,023.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,857,609,906.43</u>	<u>4,473,428,962.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,857,609,906.43	4,473,428,962.81
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	3,823,296,667.43	4,439,318,047.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,331,381,279.00	4,890,321,079.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-723,277,382.44	-820,721,169.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,989,493.41	359,297,933.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-84,147,372.58	-106,459,289.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,557,063.73	170,489,863.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-88,629,149.41	-100,003,871.42
39217	Ном	28,422,735.72	46,393,502.14
393	Биет бус хөрөнгө	34,313,239.00	34,110,915.04
39301	Програм хангамж	2,273,239.00	2,273,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-790,000.00	-992,323.96
39303	Бусад биет бус хөрөнгө	32,830,000.00	32,830,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,167,736,367.72</u>	<u>4,991,738,203.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,493,000.00</u>	<u>37,916,898.10</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,493,000.00	37,916,898.10
413	Өглөг	5,493,000.00	37,916,898.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	65,998.10
4136	Бусад өглөг	5,493,000.00	37,850,900.00

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41361	Байгууллагад төлөх өглөг	5,493,000.00	37,850,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,162,243,367.72</u>	<u>4,953,821,305.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,162,243,367.72	4,953,821,305.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,471,608,356.00	1,471,608,356.00
51101	Өмч: - төрийн	1,471,608,356.00	1,471,608,356.00
512	Хуримтлагдсан үр дүн	-189,452,704.22	602,125,233.42
51210	Өмнөх үеийн үр дүн	-189,452,704.22	-189,452,704.22
51220	Тайлант үеийн үр дүн		791,577,937.64
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,880,087,715.94	2,880,087,715.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,167,736,367.72</u>	<u>4,991,738,203.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,966,360,061.52	4,677,433,251.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,768,800.00	738,753,351.92
120	Нийтлэг татварын бус орлого	2,768,800.00	738,753,351.92
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	4,350,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,350,900.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	2,768,800.00	706,319,706.42
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	28,082,745.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,963,591,261.52	3,938,679,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,721,434,261.52	3,648,419,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,466,547,400.00	3,648,419,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	254,886,861.52	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	242,157,000.00	290,260,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	242,157,000.00	290,260,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,616,385,443.76	3,885,855,314.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,616,385,443.76	3,885,855,314.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,535,509,950.76	3,775,792,797.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,824,390,105.71	2,750,313,580.37
210101	Үндсэн цалин	1,222,096,227.62	1,694,094,962.90
210102	Нэмэгдэл	520,124,279.14	927,419,151.47
210104	Урамшуулал	82,169,598.95	128,799,466.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,136,200.00	349,154,577.00

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	156,492,900.00	240,717,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	18,410,600.00	28,319,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,728,800.00	14,159,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,681,900.00	14,159,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	36,822,000.00	51,797,277.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,699,310.00	320,201,048.25
210301	Гэрэл, цахилгаан	13,488,690.00	16,194,850.25
210302	Түлш, халаалт	148,210,620.00	304,006,198.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,092,079.14	39,165,045.00
210401	Бичиг хэрэг	10,255,250.00	4,220,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,263,430.00	5,357,610.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,573,399.14	29,587,435.00
2105	Нормативт зардал	141,498,074.16	128,758,061.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	
210502	Хоол, хүнс	141,320,074.16	128,758,061.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	133,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,223,900.00	-
210604	Урсгал засвар	3,223,900.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,629,650.00	22,424,390.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,350,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	74,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,555,650.00	18,073,490.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,840,631.75	165,776,095.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,557,192.86	33,570,345.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,361,000.00	873,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	118,922,438.89	131,332,750.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,875,493.00	110,062,516.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,875,493.00	110,062,505.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80,875,493.00	89,706,215.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	20,356,290.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11.75
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		11.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>349,974,617.76</u>	<u>791,577,937.64</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>349,974,617.76</u>	<u>791,577,937.64</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2708704400.00</u>	<u>3,938,679,900.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2708704400.00	3,938,679,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2466547400.00	3,648,419,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2466547400.00	3,648,419,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	242157000.00	290,260,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	242157000.00	290,260,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2510361112.61</u>	<u>3,733,117,155.14</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2510361112.61	3,733,117,155.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2454559752.61	3,626,948,628.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1824390105.71	2,748,606,182.27
210101	Үндсэн цалин	1222096227.62	1,661,627,613.80
210102	Нэмэгдэл	520124279.14	927,419,151.47
210104	Урамшуулал	82169598.95	159,559,417.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230136200.00	350,795,977.00
210201	Тэтгэврийн даатгал	156492900.00	240,717,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	18410600.00	28,319,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14728800.00	14,159,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3681900.00	14,159,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	36822000.00	53,438,677.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	241273000.00	288,884,988.25
210301	Гэрэл, цахилгаан	11549790.00	13,694,850.25
210302	Түлш, халаалт	229723210.00	275,190,138.00
2105	Нормативт зардал	94353566.90	122,031,075.00
210502	Хоол, хүнс	94353566.90	122,031,075.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	884000.00	1,375,000.00
210604	Урсгал засвар	884000.00	1,375,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10198650.00	26,402,635.87
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10198650.00	26,402,635.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53324230.00	88,852,770.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36594300.00	70,148,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16729930.00	18,703,820.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55801360.00	106,168,526.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	55801360.00	106,168,515.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55801360.00	85,812,225.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		20,356,290.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	11.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		11.75

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>198343287.39</u>	<u>205,562,744.86</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	50904000.00	40,832,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50904000.00	40,832,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50904000.00	40,832,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50904000.00	40,832,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-50904000.00</u>	<u>(40,832,100.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	147439287.39	164,730,644.86
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67144199.61	214,443,487.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	214443487.00	379,174,131.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-539,427,321.98	-539,427,321.98
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-539,427,321.98	-539,427,321.98
C07	Тайлант үеийн үр дүн			349,974,617.76	349,974,617.76
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-189,452,704.22	-189,452,704.22
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,471,608,356.00	2,880,087,715.94	-189,452,704.22	4,162,243,367.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,471,608,356.00	2,880,087,715.94	-189,452,704.22	4,162,243,367.72
D08	Тайлант үеийн үр дүн			791,577,937.64	791,577,937.64

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,471,608,356.00	2,880,087,715.94	602,125,233.42	4,953,821,305.36
-----	--	-------------------------	-------------------------	-----------------------	------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		214,443,487.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,172,303,900.00	3,773,949,255.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,172,303,900.00	3,773,949,255.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,042,545,800.00	3,665,518,918.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,884,012,700.00	2,746,344,372.27
210101	Үндсэн цалин	1,746,609,300.00	1,659,365,803.80
210102	Нэмэгдэл	1,022,307,800.00	927,419,151.47
210104	Урамшуулал	115,095,600.00	159,559,417.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	360,501,600.00	350,795,977.00
210201	Тэтгэврийн даатгал	245,141,000.00	240,717,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	28,840,100.00	28,319,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,420,100.00	14,159,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,420,100.00	14,159,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	57,680,300.00	53,438,677.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	313,043,000.00	288,884,988.25
210301	Гэрэл, цахилгаан	8,687,000.00	13,694,850.25
210302	Түлш, халаалт	304,356,000.00	275,190,138.00
2105	Нормативт зардал	252,966,200.00	122,031,075.00
210502	Хоол, хүнс	252,966,200.00	122,031,075.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,375,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,375,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,023,800.00	27,942,635.87
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,023,800.00	27,942,635.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	181,498,500.00	128,144,870.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,073,300.00	106,721,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,425,200.00	21,423,820.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,758,100.00	108,430,336.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	129,758,100.00	108,430,336.75
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	107,140,000.00	85,812,225.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,618,100.00	22,618,100.00
213209	Төвлрүүлэг шилжүүлэг		11.75

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,172,303,900.00	3,938,679,888.25
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,648,419,900.00	3,648,419,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,648,419,900.00	3,648,419,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	314,543,000.00	290,259,988.25
132001	Орон нутгийн төсвөөс	314,543,000.00	290,259,988.25
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	209,341,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	209,341,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		214,443,487.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		379,174,131.86
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	120.00	120.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	79.00	79.00
620003	Үйлчлэх ажилтан	38.00	38.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь сурагчдад анхан болон суурь мэдлэг олгох, сурлагын чанарыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах зарим өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2023 онд баримтын шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/211 тоот тушаалаар баталсан НББ-ийн бүртгэлийн бодлогын баримт бичгийг ажилдаа мөрдлөг болгосон байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/299 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 824.0 сая төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	214,443.5	379,174.1	164,730.6
Авлага	0.00	4,350.90	4,350.9
Бараа материал	95,682.9	134,784.2	39,101.2
Үндсэн хөрөнгө	3,857,609.9	4,473,428.9	615,819.1
Нийт хөрөнгө	<u>4,167,736.4</u>	<u>4,991,738.2</u>	<u>824,001.8</u>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,162,243.4	4,953,821.3	4,162.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>4,167,736.4</u>	<u>4,991,738.2</u>	<u>824,001.8</u>

Дээрх хүснэгтээс харахад мөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39.1 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 272.3 сая төгрөгийн материал худалдан авч, үйл ажиллагаанд 261.3 сая төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна. Үүнд: Хүнсний материалаас 218.5 сая төгрөгийн, аж ахуйн материалаас 29.7 сая төгрөгийн, бичиг хэргийн материалаас 4.0 сая төгрөгийн, түлш, шатах тослох материалаас 9.0 сая төгрөгийн, эм боох материалаас 0.2 сая төгрөгийн материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө 615.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 40.8 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 706.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгөд 131.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр 791.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,862.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,862.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 3,230.2 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,857.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 314.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийтдээ 4,172.3 сая төгрөгийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,648.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 290.3 сая төгрөгийн санхүүжилт авч, нийтдээ 3,773.9 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,773.9 сая төгрөг буюу 90.4 хувьтай байна. Харилцах дансанд 379.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна. Орон нутгийн санхүүжилтийг 24.3 сая төгрөгөөр, улсын төсвийн санхүүжилтийг 3.8 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80217-Мэдээлэл технологийн үйлчилгээ	-	-	-	-
2	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	5,219.6	5,219.6	-	100.0
3	80233-Хүүхэд хамгаалал	5,426.4	242.2	(5,184.2)	4.5
4	80304-Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	-	-
5	80312-Сургалт семинар	4,217.1	2,462.4	(1,754.7)	58.4
6	81605-Эрүүл мэндийг дэмжих	7,862.5	5,185.0	(2,677.5)	65.9
7	213205-Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урам	107,140.0	85,812.2	(21,327.8)	80.1
8	81806-Дотуур байрны үйлчилгээ	887,055.6	727,343.5	(159,712.1)	82.0
9	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	66,027.7	43,968.0	(22,059.7)	66.6
10	81823-Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	19,496.8	530.0	(18,966.8)	2.7
11	81827-Бичиг үсгийн боловсролын хөтөл	34,382.0	34,381.1	(0.9)	100.0
12	81834-Боловсролын стандарт, сургалты	2,554,029.0	2,414,921.2	(139,107.8)	94.6
13	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	157,897.4	156,845.9	(1,051.5)	99.3
14	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	9,006.8	6,778.1	2,228.7	75.3
15	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	314,543.0	290,260.0	2,228.7	92.3
	Дүн	4,172,303.9	3,773,949.2	(398,354.7)	90.4

4,172,303.9

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Улаанхус сумын 1 дүгээр ахлах сургууль нь ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй, Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн 210801 дансанд төсөв тусгагдаагүй ба бараа үйлчилгээний бусад зардлын 210901 дансаар 70.1 сая төгрөгийг зарцуулсан ба алдаа, зөрчил ирээгүй.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд 272.3 сая төгрөгийн бараа материал, 40.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн №1/04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2,616.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 39.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Байгууллагын 3,230.1 сая төгрөгийн батлагдсан төсвийг мэдээлэх ёстойгоос 387.1 сая төгрөгийг мэдээлж 2,843.0 сая төгрөгийг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн 121.7 сая төгрөгийн зөрчлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй, анх баталсан төсвөөс тухайн жилийн төсөвт /зорилтот түвшинд/ орсон нэмэлт, өөрчлөлтөөр нэмэгдсэн 243.1 сая төгрөгийн мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор мэдээлэх 21 гүйлгээний 354.6 сая төгрөгийн 12 гүйлгээний 201.9 сая төгрөгийг мэдээлж, 9 гүйлгээний

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

152.6 сая төгрөгийг мэдээлээгүй нийтдээ 3,360.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй ба шилэн дансны хэрэгжилт 87.2 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах зөвлөмж өгөгдлөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 82.2 сая төгрөгийн албан шаардлага, 39.5 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	82,212.0	1	82,212.0	
Зөвлөмж	1	39,550.0	1	39,550.0	100
Нийт дүн	2	121,762.0	2	121,762.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн боловч цаг хугацааны асуудлаар бүрэн шалгах боломжгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 84.7 сая төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зарлагын төлөвлөгөөг 60.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зарлагын төлөвлөгөөний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн орон нутгаас санхүүжих эс үүсвэрийг 24.3 сая төгрөгөөр дутуу тус тус тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах журам”, 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 3,365.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 5.0 сая төгрөгийн албан шаардлага, 3,360.6 сая төгрөгийг зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 5.0 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

Сургуулийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн Б/71 тоот тушаалаар 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр "Өөрчлөлтгүй" дүгнэгдсэн нягтлан бодогч, нярав нарт 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нийтдээ 5.0 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгож, төсвийг үр ашиггүй, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх талаар албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Өмнөх оны аудитаар өгсөн 121.8 сая төгрөгийн зөрчлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй, анх баталсан төсвөөс тухайн жилийн төсөвт /зорилтот түвшинд/ орсон нэмэлт, өөрчлөлтөөр нэмэгдсэн 243.2 сая төгрөгийн мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор мэдээлэх 21 гүйлгээний 354.6 сая төгрөгийн 12 гүйлгээний 201.9 сая төгрөгийг мэдээлж, 9 гүйлгээний 152.6 сая төгрөгийг мэдээлээгүй нийтдээ 517.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй ба шилэн дансны хэрэгжилт 87.2 хувьтай байна.

Өмнөх онд аудитаар өгсөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 114.8 сая төгрөгийн 13 мөнгөн гүйлгээг ил тод мэдээлэхээс 9 удаагийн 82.2 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байсан бол тайлант онд тус зөрчлийг арилгаж тайлант онд ил тод мэдээлсэн байна

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлээгүй дээрх мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, Шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах.

2. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй / хоолны зардал 122.0 сая төгрөг, Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал /үдийн хоол/ зардал 85.8 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд зарлагын төлөвлөгөөг дутуу тайлагнасан	1	60,385.3	1	60,385.3			1	60,385.3				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд зарлагын санхүүжүүлэх эх үүсвэрийг дутуу тайлагнасан	1	24,283.0	1	24,283.0			1	24,283.0				
Дүн	2	84,668.3	2	84,668.3			2	84,668.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн урамшуулал илүү олгосон	1	5,026.0			1	5,026.0						
Дүн	1				1							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1	517,602.2					1	517,602.2
Дүн	1	517,602.2					1	517,602.2
Засгийн газрын тогтоол, сайдын тушаалтай холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Нийт дүн	2	517,602.2					2	517,602.2